



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/135

Бор-Өндөр сум

**Хагас жилийн мал тооллого
явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.в дэх заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/319 дугаар захирамжийн дагуу Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 2025 оны 06 сарын 10-ны өдрийн хооронд явуулсугай.

2. 2025 оны хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Галбадрах

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Б.Оюунтуяа

Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Гишүүд:

И.Энхтуяа

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

У.Пүрэвсүрэн

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Д.Мөнгөнтуяа

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Ч.Саруулмөнх

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Б.Мөнх-Оргил

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Н.Отгонбилэг


Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

Э.Гуамарал

Хүйх 5 дугаар багийн Зохион байгуулагч

3. Хагас жилийн мал тооллогын ажлыг 2025 оны 06 сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулан, цахим шивэлтийг 2025 оны 06 сарын 16-ны өдрийн дотор дуусгаж сумын Засаг даргад илтгэх хуудсаар 2025 оны 06 сарын 16-ны өдөр танилцуулахыг ажлын ахлагч /Х.Галбадрах/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ГАДЪЯАБИЛЭГТ